

МУИС-ИЙН ХАРЬЯА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ДОРНОД АХЛАХ СУРГУУЛИЙН XI АНГИЙН НИЙГЭМ
СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа 80 минут

Анги:

Овог,нэр:

Сэргээн санах

- Иргэний эрхтэй эсэхээр ялгагддаг, нэг нь нөгөөгийнхөө өмч нь болж байдаг, албадлагын хөдөлмөрийн харилцаанд тулгуурласан, байр сууриа өөрчлөх боломжоор хомс, эртний Грек, Ром, өмнөд Америк, XX зууны Германы нацист, ЗХУ-ын коммунист хорих лагерьт байсан давхраажилтын хэв маяг аль нь вэ?

A. Каст	B. Боолчлол	C. Язгуур	D. Анги
---------	-------------	-----------	---------
- “Хүнд төрөлхөөс заяасан 3 эрх байна. Энэ нь амьдрах эрх, эрх чөлөөтэй байх эрх, өмчлөх эрх юм.” гэж хэн хэлсэн бэ?

A. Жон Локк	B. Дж.Кэмпбелл	C. Э.Фромм	D. К.Оберг
-------------	----------------	------------	------------
- Валютын интервенци хэмээх ойлголтыг илэрхийлсэн тодорхойлолтыг доорх өгөгдлүүдээс сонгоно уу.

A. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ	B. Төв бакнаас валютын ханшийг өсгөх үйл ажиллагаа	C. Төв бакнаас валютын ханшийг бууруулах үйл ажиллагаа	D. Төв банк өөрийн нөөцөөр валютыг худалдан авах үйл ажиллагаа
--	--	--	--
- гэдэг нь төрөөс үл хамаарах өөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагддаг хувь хүмүүс, анги, бүлэг, институтуудын нийлбэр цогц юм.

A. Уламжлалт нийгэм	B. Орчин үеэс өмнөх нийгэм	C. Иргэний нийгэм	D. Төрийн институт
---------------------	----------------------------	-------------------	--------------------
- Монгол улсын шүүхийн тогтолцооны зөв бүтцийг тэмдэглэнэ үү.

A. Улсын дээд , аймаг нийслэлийн , сумын, сум дундын, дүүргийн шүүх	B. Улсын дээд, хотын, нийслэлийн, багийн, хорооны, дүүргийн шүүх	C. Монголын, аймгийн, баруун, зүүн төвийн бүсийн, говийн шүүх	D. Улс төрийн, шашны, олон нийтийн байгууллагын, захиргааны шүүх
---	--	---	--
- Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг доромжилсон, худал мэдээллийг нийтэд дэлгэсэн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн заалт аль хуулинд хамаарах вэ?

A. Монгол улсын Үндсэн хууль	B. Зөрчлийн тухай хууль	C. Хүний эрхийн түгээмэл тунхаглал	D. Эрүүгийн хууль
------------------------------	-------------------------	------------------------------------	-------------------
- Монгол улсын гадаад бодлогод 1990 оноос хойш өргөн хэрэглэгдэх болсон гол нэр томъёо аль нь вэ?

A. Гуравдагч хөрш	B. Оюун санааны хөрш	C. Хөрш орнууд	D. Хоёр хөршийн харилцаа
-------------------	----------------------	----------------	--------------------------
- Төр засгийн оролцоогүйгээр сайн дурын үндсэн дээр иргэдийн санаачилсан үйл хэрэг хэрэгжиж улс байгууллага хоорондын харилцаанд тодорхой үүрэг чиглэлээр оролцох нь дараах ойлголтуудаас алиныг нь илэрхийлж байна вэ?

A. Иргэн олон улсын харилцааны оролцогч	B. Олон улсын харилцааны улс бус оролцогч	C. Олон улсын харилцааны үндсэн оролцогч	D. Ардын дипломат
---	---	--	-------------------

Ойлгох

9. Хувь хүний давхраажилтын байр суурийг тодорхойлох субъектив хэмжүүр нь аль нь вэ?
- A. Тухайн хүний сард олж буй орлогын хэмжээ B. Тухайн хүний хүмүүжил төлөвшлийн байдал C. Эзэмшсэн боловсрол мэдлэг D. Тухайн хүн өөрийгөө ямар давхрагад хамрахыг дүгнэх үнэлгээ
10. Соёлын үйлдвэрлэлд оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой бүтээл туурвил, үйлчилгээ багтана. Үүнд хамаарах ойлголт аль нь вэ?
- A. Соёлын цахим хэвлэл B. Соёлын аялал жуучлал C. Соёлын даяаршил D. Соёлын орон зай
11. Капиталын экспортын үндсэн хэлбэр аль нь вэ?
- A. Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба Портфелийн хөрөнгө оруулалт B. Хөдөлмөрийн экспорт ба Капиталын импорт C. Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба Хөдөлмөрийн экспорт D. Портфелийн хөрөнгө оруулалт ба Капиталын импорт
12. Эдийн засгийн өсөлтийг урамшуулдаг ч инфляцийн эсрэг хүчин мөхөсддөг төрийн макро эдийн засгийн бодлого аль нь вэ?
- A. Сангийн бодлого B. Мөнгө, зээлийн бодлого C. Мөнгөний тэлэх бодлого D. Мөнгөний хумих бодлого
13. Улс төрийн системийн гаралтын чиг үүрэг нь улс төрийн аль институтын мэдэлд байдаг вэ ?
- A. Төр B. Хөдөлгөөн, Төрийн бус байгууллага C. Улс төрийн намууд D. Сонирхолын бүлэг
14. Сонирхлын бүлэг гэдэг нь хувийн эрх ашгийн төлөө бус, бүлгийн буюу нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор иргэдээс сайн дураар үүсгэн байгуулсан байгууллага, хөдөлгөөн юм. Сонирхлын бүлгийн үйл ажиллагаа нь нийгэм дэх олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах юм. Энэхүү үндсэн чиг үүрэг аль нь вэ?
- A. Артикуляци B. Агрегаци C. Интеграци D. Аномик
15. нь тухайн улсын хуулийн дагуу иргэдийн биелүүлбэл зохих шаардлагуудын цогц юм. Цэгийн оронд нөхөж гүйцээнэ үү.
- A. Иргэний эрх B. Иргэний үүрэг C. Иргэн D. Хууль
16. Захиргааны байгууллага, хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд туслах чиг үүрэгтэй оролцож буй этгээдийг бусад оролцогч гэдэг. Бусад оролцогчид аль нь хамаарахгүй вэ?
- A. Гэрч, өмгөөлөгч B. Хэлмэрч, орчуулагч C. Шинжээч D. Гуравдагч этгээд
17. Зөөлөн хүчний бодлогын мөн чанарыг илэрхийлсэн тодорхойлолтыг олно уу.
- A. Улс өөрийн үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улс төр, стратеги, эдийн засаг, соёл гэх зэрэг бүх арга хэрэгслээ тэнцвэртэй хоршуулах чадвар B. Их гүрнүүд цэрэг, эдийн засгийн хүч чадавхаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэх C. Албадлага урамшууллаар бус харин бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсэж буй үр дүнд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадвар D. Олон улсын харилцаанд оролцогч улс орнууд өөрийн хүч чадавхаас хамаарч хатуу, зөөлөн хүчний бодлого стратегийг сонгодог.
18. Монгол улсын түншлэлийн харилцаатай улсуудыг дурьдахдаа илүүц улсыг дурьдсан бол аль нь вэ?

A.ОХУ, Япон,Энэтхэг

В.БНСУ, АНУ,
Герман,Турк

С.БНАСАУ, Швед

D.Канад, Австрали

Хэрэглэх

19. Тодорхой цаг хугацааны хүрээнд ... шинэчлэгдэхийг нийгмийн өөрчлөлт гэнэ.

A. Нийгмийн бүтэц, соёл,
нийгмийн институт,
хүмүүсийн зан үйл

В. Үйлдвэрлэлийн арга,
арилжааны хэрэгсэл,
байгалийн нөөц

С. Нийгмийн давхраа,
үндэс угсаа, боловсрол,
мэдлэг

D. Засаглалын бүтэц,
байгалийн нөхцөл, улс
төрийн нөхцөл байдал

20. Гэр бүл, гэрлэлтийн харилцаа өөрчлөгдөж, гэрлэлтийн нас хойшилж, ганц бие амьдрахыг илүүд үзэх болсон бөгөөд гэр бүлийн үнэт зүйлс нийтлэг зарчим гэхээс хувь хүний сонирхлыг тэргүүнд тавих хандлага өсөж байгаа нь аль нийгмийн шинж вэ?

A. Орчин үеийн буюу аж
үйлдвэржилтийн дараах
нийгэм

В. Орчин үеийн буюу аж
үйлдвэржсэн нийгэм

С. Аж үйлдвэржсэн нийгэм

D. Уламжлалт буюу аж
үйлдвэржилтээс өмнөх
нийгэм

21. Хүмүүсийг соёлын өвөрмөц хэв шинжээс нь болж нийгэм, эдийн засаг улс төрийн амьдралд оролцох боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхах нь соёлын эрх чөлөөг зөрчих хандлагын аль нь вэ?

A. Нийгмийн амьдрал
дахь оролцоог хязгаарлах

В. Амьдралын хэв маягийг
үгүйсгэх

С. Иргэдийн соёлыг
оролцуулан бүх соёлыг
ижил тэгш үнэлж,
хүндэтгэх

D. Хувь хүний сонголт
хийх бололцоог
өргөжүүлэх

22. Соёлын эрх чөлөө нь тухайн хүний харьяалж буй улсаас их шалтгаалдаг. Манай улсын хувьд 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш нийгмийн оюун санааны амьдралд олон өөрчлөлт гарсан байна. Зөв өгөдлийг олно уу?

A. Үндэсний үзэл санаа,
соёл уламжлалаа сэргээх
эрх чөлөө

В. Сүм хийд хаах, шүтэн
бишрэх эрх чөлөөг
хязгаарлах

С. Бусад улс оронд
суралцах, аялан
жуулчлах, ажиллаж
амьдрахыг хориглох

D. Хүний эрхийн зөрчил,
хүчирхийлэл, аливаа
шударга бус үйлдэлийг
нуух

23. Бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогоос түүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан зардлыг хасаж үйлдвэрлэлийн ашиг, алдагдлын хэмжээг тодорхойлдог. Гадаад худалдааны ашиг, алдагдлыг үүний нэгэн адил тооцдог. Гадаад худалдааны зардлыг илэрхийлэх ойлголт аль нь вэ?

A. Экспорт

В. Импорт

С. Ашиг

D. Алдагдал

24. Мөнгө зээлийн “Зөөлөн бодлого”-д хамаарахыг олоорой.

A. Зээлийн хүүг бууруулах.

В. Зээлийн хэмжээг
нэмэгдүүлэх.

С. Зээлийн хэмжээг
багасгах.

D. Зөвхөн А ба В

25. Сонгуулийн эрх хэмээх ойлголтод хамаарах жишээ аль нь вэ ?

A. Содбилэг 2016 оны
Улсын их хурлын
сонгуульд нэр дэвшиж
өрсөлдсөн.

В. Мөнхгэрэл 2016 оны
Улсын их хурлын
сонгуульд нэр дэвшигчийн
төлөө саналаа өгсөн.

С. Даариймаа 2016 оны
Улсын их хурлын
сонгуулийн тойргийн
сурталчилгааны компани
ажилд оролцсон.

D. А ба В хамаарна.

26. Шийдвэр ба үйлдэл нь улс төрийн системийн аль сувагт хамаарах вэ?

A. Гаралт

В. Хувиралт

С. Эргэх холбоо

D. Оролт

27. Тамхины хяналтын тухай хуулинд зааснаар кино театр, үзвэрийн газрууд, агаарын тээвэр, цэцэрлэг, бүх шатны сургууль, дотуур байрны гадна, дотор орчин, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн орон сууцны орц, цахилгаан шатанд тамхи татахыг бүрэн хориглосон байдаг. Тэгвэл иргэн болон байгууллага нь энэхүү хуулийн заалтыг зөрчвөл ямар хариуцлага хүлээлгэх вэ?

A. Торгох

B. Тусгайлан олгосон эрхийг нь цуцлах

C. Баривчлах

D. Хууль бус орлогыг хураах

28. Цагдаагийн байгууллага гэмт хэргийг шалгаж, прокурор түүнд нь хяналт тавьж, гэмт хэрэгтнийг хэрхэн шийтгэх дүгнэлтээ шүүхэд ирүүлсний дараа тухайн шүүх хэргийг хэлэлцэж шийдвэрлэх үйл ажиллагааг юу гэж нэрлэх вэ?

A. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

B. Шүүх үйл ажиллагаанд хяналт тавих

C. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх

D. Эрүүгийн хэрэг үүсгэн шалгах

29. "ОХУ болон БНХАУ – тай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзан үзнэ." гэсэн нь Монгол улсын гадаад бодлогын аль зорилтонд хамаарах вэ?

A. Гадаад бодлогын гуравдахь чиглэл

B. Гадаад бодлогын хоёр дахь чиглэл

C. Гадаад бодлогын эн тэргүүний зорилт

D. Гадаад бодлогын зарчим

30. Тухайн бүс нутагт ашиг сонирхлын зөрөлдөөнтэй олон асуудал байх тул тус бүс нутгийн орнууд болох ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, БНАСАУ зэрэг улсуудын бодлогоос бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагаа шууд хамааралтай юм. Энэ нь аль бүс нутгийн тухай ярьж байна вэ?

A. Зүүн хойд ази

B. Зүүн ази

C. Зүүн өмнөд ази

D. Ази ба Номхон далайн бүс

Задлан шинжлэх

31. Нийгмийн хөдөлгөөний жишээг зөв харгалзуулна уу?

1	Хүн амын өсөлт	A	Дэлхийн нэгдүгээр дайны дараагаар өрөнд орсон Герман улс эдийн засгийн гүнзгий хямралд өртөж, энэхүү нөхцөл байдал нь хэсэг хугацааны дараагаар Гитлерийн нацист үзэл суртал түгэн дэлгэрэхэд хүргэсэн.
2	Соёл технологи	Б	1990, 2000-аад онуудад болсон зуднаар малаа алдсан малчид амтжиргаагаа залгуулах, ажилтай болох үүднээс томоохон суурин руу шилжин суурьшиж амьдрах болсон
3	Хүрээлэн буй орчны хүчин зүйлс	В	Бичиг үсэг, шинжлэх ухаан, технологи ч хүн төрөлхтний түүхэн өөрчлөлтийг дагуулжээ.
4	Дайн улс төрийн мөргөлдөөн	Г	Нийгмийн шинэчлэлийн нөлөөгөөр эрчимжсэн. XX зуунд дэлхийн хүн ам 1,65 тэрбумаас 6 тэрбус болтлоо. Монгол улс хүн ам 647,5 мянгаас 2373,5 мянга болж буюу бараг 4 дахин өссөн.

32. Доорх ойлголтыг нөхөж бичээрэй.

Бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх эрхийг (.....) гэнэ. Хүн бүр бусдын эрхийг хүндлэн өөрийн үйлдлээ сонголтын үндсэн дээр хийх боломж, түүний баталгааг хэлнэ үүнийг (.....) гэнэ. Хүн бүрт олгогдсон адил тэгш боломжийг (.....) гэнэ. Өөр соёлын орчин нөхцөл тухайн хүний хүссэнээс огт өөр байх бүтэлгүйтэх, сэтгэл ханамж мэдрэгдэхгүй байх үед үүсэх бухимдал гутрал түгшүүр гэх мэт сөрөг мэдрэмж үүсэх үеийн сэтгэл зүйн байдлыг (.....) гэнэ.

Сонгох үг: эрх чөлөө, Соёлын цочирдол хүний эрх, соёлын эрх чөлөө

33. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Эрүүгийн хариуцлага	A	Хувь хүний чадавхи болон боломжийг өргөжүүлэх үйл явц
2	Хүний эрх	Б	Төрөөс тогтоосон заавал биелүүлэх хэм хэмжээний цогц
3	Хууль	В	Хуулиар тогтоосон ял шийтгэл хүлээх гэм буруугийн төрөл
4	Хүний хөгжил	Г	Хүн болж төрсний хувьд заяасан боломжууд

34. Иргэн С өглөө эрт ажилдаа явахаар гэрээсээ гартал хажуу айлын хөрш Я-г хоёр залуу зодож байв. Иргэн С зодооныг харсан хэрнээ цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөөгүй.

Иргэн С-ийн үйлдэл гэмт хэрэг үйлдсэнд тооцогдох уу?

.....

34.2. Эрх зүйн зөрчлийг хэрхэн ангилдаг вэ?

.....

34.3. Гэмт хэргийн зөрчлийг ямар хуулиар шийдэхээр тусгасан байдаг вэ?

.....

34.4. Гэмт хэргийн бус зөрчилд ямар зөрчлүүд хамаарах вэ?

.....


35. Эдийн засгийн дараах үндсэн ойлголтуудыг зохих агууллагатай нь зөв тохируулна уу?

№	Үндсэн ойлголт		Агуулга
1	Төсвийн хомсдол	А	Төсвийн зардлаас орлого давах тохиолдол
2	Улсын өр	Б	Хэд хэдэн жилээр хуримтлагдсан төсвийн хомсдол
3	Төсвийн илүүдэл	В	Төсвийн орлогоос зарлага давах тохиолдол
4	Шууд бус татвар	Г	Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс, ААН-ээс авах татвар

36. Протекционист бодлогын эсрэг бодлого бөгөөд гадаад худалдаанд төр оролцох ёсгүй, тэр нь чөлөөт зах зээлийн жамаар тухайлбал, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, өрсөлдөөний хуулиар хөгжих ёстой гэсэн зарчмыг баримталдаг учраас татварыг бууруулах, бусад хязгаарлалтуудыг үгүй болгоход чиглэгддэг. Энэ бодлогыг..... гэнэ.

36.2 Гадаад худалдааны орлого буюу гадаад худалдааны зардлыг буюу хасаж гадаад худалдааны ашиг, алдагдлыг тодорхойлно.

36.3 Дараах бүдүүвчийг нөхөж бичээрэй?



36.4 Монгол улсын гадаад худалдааны үндсэн үзүүлэлт, жилээр /сая.ам,доллар/ хүснэгтэн мэдээллийг ашиглан дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Нийт эргэлт	8,466.80	8,274.48	10,537.90	12,886.80	13,747.20
Экспорт	4,669.30	4,916.34	6,200.60	7,011.80	7,619.80
Импорт	3,797.50	3,358.14	4,337.30	5,875.00	6,127.40
Тэнцэл	871.80	1,558.20	1,863.30	1,136.70	1,492.30

Экспортийн хэмжээ хэдэн онд хамгийн бага байсан бэ?

37. Америкийн улс төр судлаач А.Алмонд сонирхлын бүлгийг өөрсдийнх нь өвөрмөц байдал дотоод зохион байгуулалтаас хамааран доорх хэв шинжид хуваан авч үзсэн байдаг. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Аномик	А	Цэрэг зэвсэглэл, арми сүм хийд зэрэг субъектын шууд удирдлаган дор зохион байгуулалтай үүсгэн байгуулагддаг.
2	Эвлэл холбооны	Б	Зохион байгуулалтгүй боловч хүмүүс голдуу яс үндэс угсаа гарал, арьс өнгө, шашин шүтлэг нас хүйс зэрэг нийтлэгээрээ хамрагддаг.
3	Эвлэл холбооны бус	В	Өөрийн гэсэн тодорхой зорилго чиглэлтэй зохион байгуулалтай бүлэг


4	Байгууллагажсан	Г	Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт бослого үймээн
---	-----------------	---	---

38. Хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч, улс төрийн нам эвсэлээс иргэн хүн тэгш эрхтэйгээр сонголтоо өөрийн биеэр чөлөөтэй хийж, үр дүн нь шууд гардаг улс төрийн сонголтыг гэнэ.

38.2. Сонгуулийн эрхийг юу гэж анилдаг вэ?

38.3. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх нь, сонгогч бүр ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдлыг хангах хэрэгтэй..... гэсэн нь сонгуулийн ямар ямар зарчмыг тухай өгүүлж байна вэ?

38.4. Дараах бүдүүвчийг нөхөж бичээрэй



39. Улс бус оролцогчдын ангилалыг зөв харгалзуулна уу?

1	Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ	А	Хүн хулгайлах, зэвсгийн наймаа, хар тамхи
2	Үндсэтэн дамнасан корпорацууд	Б	Буддын шашны төвүүд, Католик сүм, Ватикан,
3	Шашны байгууллага	В	BBC, CNN, Фэйсбүүс, Твитер
4	Олон улсын гэмт хэргийн сүлжээ	Г	Тоёото, Walmart, CocaCola

40. Манай улсад Японы Гадаад хэргийн сайд Т.Коно өнгөрсөн зун айлчиллаа.Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоогоод 47 жил болжээ. Монгол нь ардчилсан нийгэмд шилжсэн 1990-ээд оноос хойш хоёр орны харилцаа жил бүр улам өргөжин гүнзгийрлээ. Гуравдагч хөрш гэж нэрлэдэг орнуудаас хамгийн түрүүн Японтой (2010 он) Стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон бөгөөд энэ хөршүүд дотроос чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан анхны улс нь Япон болжээ. /Эх сурвалж, Засгийн газрын мэдээ сонин 2020.05.01 ны дугаар/

40.1 Монгол улс Япон улстай хэдий үеэс дипломат харилцаа тогтоосон вэ?

.....

40.2 Хоёр улсын харилцаа хэдий үеэс эрчимтэй хөгжиж эхэлсэн вэ?

.....

40.3 Стратегийн хамтын ажиллагаа гэж юу вэ?

.....

40.4. Монгол улс Япон улстай түншлэлийн харилцаа тогтоосон нь ямар давуу талыг авчирсан бэ?

.....